



МОНГОЛ УЛСЫН
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 27 99, Факс: (976-11) 26 27 98,
Цахим шуудан: info@nird.gov.mn
Цахим хуудас: www.regional.gov.mn

2024.11.23 № 24/97

танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ-аас 2024 оны 11 сарын 14-ний өдөр зарласан “Бүсийн тээвэр, логистикийн төвийн ТЭЗҮ” /Дархан-Уул, Дархан сум/ (МУШС/20240103034)-ийн үйлчилгээ үзүүлэх ажилд ирсэн тодруулгын хариуг үүгээр хүргүүлж байна.

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	Манай байгууллага нь “Төмөр замын зураг төсөл боловсруулах” үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ нь хүчин төгөлдөр болно. Одоогоор хоёр дахь байгууллагын Тээвэр, логистикийн зураг төсөл, ТЭЗҮ-г боловсруулж байна. Иймд манай байгууллагыг “Бүсийн тээвэр логистикийн төвийн ТЭЗҮ”-ийн тендерт оролцох боломжийг хангаж тодруулга хийж өгнө үү	Тендерийн баримт бичигт Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 147 дугаар тушаалаар баталсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам"-ын хавсралтын хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл шаардлагын 10 дахь хэсэгт Техник, эдийн засгийн үндэслэл, төсөв боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байхаар заасан тул “Төмөр замын зураг төсөл боловсруулах” үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээтэй ААН тендерт оролцох боломжгүй болно.

001524020666

2	2020.07.03 нд 5 жилийн хугацаатай олгосон БХБ-ын сайдын олгосон ЗТ-11.1 Барилга байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, төсөв тусгай зөвшөөрлөөр оролцож болох уу?	"Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам"-ын хавсралтын хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл шаардлагын ЗТ-11.1 дэх хэсэгт заасан "Машин, тоног төхөөрөмж, түүний эд ангийн үйлдвэрлэлийн зураг төсөл, кранаар ажил гүйцэтгэх төсөл"-ийн зөвшөөрөл нь тендерийн баримт бичиг заасан тусгай зөвшөөрлийн төрөлтэй нийцэхгүй байна.
---	--	--

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭРДЭНЭБАЯР

